


# ОНЛАЙНААР АВЧ БОЛОХ БҮХ ТӨРЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ LENDMN АППЛИКЕЙШНЭЭС



ОНЛАЙНААР АВЧ БОЛОХ БҮХ ТӨРЛИЙН  
ҮЙЛЧИЛГЭЭГ **LENDMN** АППЛИКЕЙШНЭЭС



LendMN



Togloom  
Trade



Онлайн  
дэлгүүр



Comedy  
Lab



Алалц  
Хож



Гадаад  
аялал



UB  
Comedy



Үзвэрийн  
билет



Номин  
Даатгал



TokTok  
Delivery



Хандив



Кино  
тасалбар



Номын  
худалдаа



Өдрийн  
хоол



Нислэгийн  
тийз



Made in  
Mongolia



Хаан  
Даатгал



Амралт,  
зугаалга



Эрүүл  
хүнс



Цэцэг  
хүргэлт



Гар урлал

ЛэндМН ББСБ ХК нь нийт харилцагч, хувьцаа эзэмшигч та бүхэндээ 2019 оны 3-р улирлын санхүү үйл ажиллагааны тайлангаа танилцуулж байна.



*Гүйцэтгэх захирал: О.Болдбаатар*

Бид хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцсэн зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд туршиж, илүү дэвшилтэт, хэмнэлттэй байдлаар LendMN аппликейшнээр дамжуулан хэрэглэгчиддээ хүргэхээр зорин ажиллаж байна.

Хэрэглэгч зээлийн үйлчилгээ авахаас LendMN аппликейшны тусламжтайгаар 25 төрлийн онлайн бүтээгдэхүүн үйлчилгээг гар утсаараа авч, төлбөр төлөлтөө Лэнд хэтэвчээр илүү хялбараар хийж байна.

- **ЗЭЭЛИЙН ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН**
- **НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭНҮҮД:**

## ДУНД ХУГАЦААНЫ ЗЭЭЛ

ЛэндМН-ийн хэрэглэгчид **LendMN** аппликейшн ашиглан 2 сая төгрөг хүртэлх барьцаагүй зээлийг 30 хоног хүртэлх хугацаатай авдаг байсан.

Бид хэрэглэгчдийнхээ санал хүсэлт, хэрэгцээ шаардлагад үндэслэн дунд хугацааны зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүллээ.

Хэрэглэгч дунд хугацаат зээлийн үйлчилгээг авснаар зээлийн хугацаа илүү уртасч 6 сая төгрөг хүртэлх зээлийг 90 хоног, 180 хоногоор зээлэн авч, авсан зээлээ сар бүр тэнцүү төлөлттэйгөөр хэсэгчлэн эргэн төлөх боломжтой юм.

Дунд хугацаат зээлийн бүтээгдэхүүнийг туршилтын журмаар зээлийн эрх болон шимтгэлийн түвшин нь хамгийн дээд түвшинд хүрсэн цөөн хэрэглэгчдэд олгож эхлээд байна.





# 6 САЯЫГ САРААР

# БАРЬЦААГҮЙ ЗЭЭЛ

## ТАТАН АВАЛТЫН ЗЭЭЛ

# ТАТАН АВАЛТ ХИЙХЭД ХЯЛБАР БОЛЛОО



## Татан авалтын зээл гэж юу?

Үндэсний үйлдвэрлэгч болон бөөний худалдаа эрхлэгчдээс бараа бүтээгдэхүүн татан авалт хийхэд зориулсан зээлийн үйлчилгээ юм.

## Бүтээгдэхүүний нөхцөл:

ХУГАЦАА	7 ХОНОГ ХҮРТЭЛ	8-14 ХОНОГ
ШИМТГЭЛ	0%	2%
ОЛГОХ	50'000₮ - 2САЯ₮	

- \* Татан авалтын зээлийн хугацаа нь 14 хоног бөгөөд эхний 7 хоногт багтаан эргэн төлөлт хийсэн тохиолдолд нэмэлт шимтгэл төлөхгүй. Харин та эргэн төлөлтөө 8-14 хоногийн дараа төлөхөд татан авалтын үнийн дүнгийн 2%-ийн шимтгэл төлнө.

## HIFIVE

Хэрэглэгч **LendMN** аппликейшн ашиглан зээлийн үйлчилгээ авахаас гадна онлайнаар авч болох бүх төрлийн хүргэлтийн үйлчилгээ, дуудлагын үйлчилгээг авч, сонирхолтой асуулт хариултын тоглоом тоглож, өөрийгөө сорих боломжтой боллоо.

**LendMN** аппликейшнд шинээр нэмэгдсэн залуучуудад зориулсан HiFive цэс нь хэрэглэгчдэд олон төрлийн сонирхолтой чалленжүүдийг санал болгох юм. Хэрэглэгч сард ердөө 900₮ төлөөд л хүссэн чалленждаа нэгдэж, өөртэйгээ ижил зорилготой олон залуустай өрсөлдөж, өөртөө цоо шинэ зуршил бий болгож өрсөлдөх юм.

# LENDMN-ээр ӨӨРИЙГӨӨ СОРИХ УУ?





## ОНЛАЙН ХИМИ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭ

Илүү ухаалаг, дэвшилтэт үйлчилгээг сонгон хэрэглэдэг хэрэглэгч та бүхэндээ зориулан Угаалга болон Хими цэвэрлэгээний онлайн захиалга, хүргэлтийн үйлчилгээг **Метро Экспресс** компанитай хамтран хүргэж эхэллээ.



# МЕТРО EXPRESS-ИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ **LENDMN**-ЭЭР АВДАГ БОЛЛОО





## ОНЛАЙН ЭМИЙН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Танд тулгарсан яаралтай асуудлуудыг шинээр нэвтрүүлсэн нэмэлт үйлчилгээнүүдийн тусламжтайгаар шийдэн ажиллаж байна.

Хэрвээ та гэрээсээ гарах боломжгүй үедээ эм эмийн бүтээгдэхүүн худалдан авах хэрэгцээ гарвал **LendMN** аппликейшны **И-Монос** цэсийг ашиглан, хэрэгцээт худалдан авалтаа Монос эмийн сангийн цахим салбараас хийж, үнэгүй хүргүүлэн аваарай.

# ЗАХИАЛГЫН ТӨЛБӨРӨӨ ЛЭНД ХЭТЭВЧ АШИГЛАН ИЛҮҮ ХЯЛБАРААР ТӨЛӨӨРЭЙ



[www.emonos.mn](http://www.emonos.mn)  
online pharmacy




## ОНЛАЙН ДУУДЛАГЫН ЖОЛООЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Автомашин эзэмшигч та **LendMN** аппликейшны **Жолооч 103** цэсийг ашиглан 100% даатгалд хамрагдсан, олон жилийн туршлагатай дуудлагын жолоочийн үйлчилгээг аваарай.

Та автомашин жолоодох боломжгүй эсвэл таны биеийн байдал таагүй, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоочийн түргэн тусламж дуудаарай.

# ДУУДЛАГЫН ЖОЛООЧИЙГ ЛЭНДМН-ЭЭР ДУУДДАГ БОЛЛОО



**103**

Жолооч  
103



- **ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА**
- **САНХҮҮГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД**
- **ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ**


## ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компанийн зээлийн бүтээгдэхүүний үндсэн үзүүлэлтүүдийг өнгөрсөн улирлын тоон үзүүлэлттэй харьцуулахад Зээлийн гэрээтэй харилцагчдын тоо **12%**, Олгосон зээлийн тоо **10%**, Олгосон зээлийн дүн **16%**, Зээлийн багц **19%** тус тус өссөн үзүүлэлттэй байна.

### 2019 ОНЫ 3-Р УЛИРЛЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙГ ӨМНӨХ ТАЙЛАНТ ҮЕҮҮДТЭЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ


#### ЗЭЭЛИЙН ГЭРЭЭТ ХАРИЛЦАГЧИД

(Өссөн дүнгээр, мянган харилцагч)




#### ОЛГОСОН ЗЭЭЛИЙН ТОО

(Мянган зээл)




#### ОЛГОСОН ЗЭЭЛ

(Тэрбум төгрөг)



#### ЦЭВЭР ЗЭЭЛИЙН БАГЦ

(Тэрбум төгрөг)



**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН /САЯ ТӨГРӨГ/**

<b>Хөрөнгө</b>	<b>2018</b>	<b>2019</b> 1-р улирал	<b>2019</b> 2-р улирал	<b>2019</b> 3-р улирал
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	3,714	1,820	3,017	1,964
Хугацаатай хадгаламж	504	-	6,698	4,269
Зээлийн багц /цэвэр/	18,767	29,941	35,791	42,727
Хүүгийн авлага	432	678	792	926
Бусад авлага	260	314	887	193
Үндсэн хөрөнгө /биет/	258	300	430	403
Биет бус хөрөнгө	388	376	365	354
Хөрөнгийн дүн	24,323	33,430	47,980	50,835

<b>Өр төлбөр</b>	<b>2018</b>	<b>2019</b> 1-р улирал	<b>2019</b> 2-р улирал	<b>2019</b> 3-р улирал
Бонд, зээл, итгэлцлийн өглөг	9,849	17,704	31,268	32,800
Хүүгийн өглөг	243	402	606	620
Хэтэвчийн өглөг	683	593	941	868
Ноогдол ашгийн өглөг	-	540	140	140
Бусад өглөг	194	929	318	593
Өр төлбөрийн дүн	10,969	19,628	33,134	34,882

<b>Өөрийн хөрөнгө</b>	<b>2018</b>	<b>2019</b> 1-р улирал	<b>2019</b> 2-р улирал	<b>2019</b> 3-р улирал
Хувьцаат капитал	10,814	10,814	10,814	10,814
Халаасны хувьцаа	-	-	-266	-266
Хуримтлагдсан ашиг /тухайн жил/	2,560	1,248	2,558	3,665
Хуримтлагдсан ашиг	-20	1,740	1,740	1,740
Өөрийн хөрөнгийн дүн	13,354	13,802	14,847	15,954
Өр төлбөр ба өөрийн хөрөнгө	24,323	33,430	47,980	50,835

**ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ ТАЙЛАН /САЯ ТӨГРӨГ/**

	2018	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019
Зээлийн шимтгэлийн орлого	6,966	3,455	4,253	4,835	12,543
Харилцах дансны хүүгийн орлого	177	15	28	81	124
Хүүгийн зардал	-512	-573	-1,095	-1,347	-3,015
Гадаад валютын ханшийн ашиг/алдагдал	0	1	-2	-8	-9
<b>Санхүүгийн цэвэр орлого</b>	<b>6,631</b>	<b>2,897</b>	<b>3,186</b>	<b>3,569</b>	<b>9,652</b>
Банк болон бусад шимтгэлийн зардал	-981	-413	-457	-514	-1,383
Шимтгэлийн дараах орлого	5,650	2,485	2,727	3,048	8,260
Зээлийн болзошгүй эрсдлийн зардал	-409	-269	-360	-533	-1,161
Эрсдлийн сангийн дараах орлого	5,242	2,216	2,368	2,515	7,098
Боловсон хүчний зардал	-1,032	-350	-423	-552	-1,325
Үйл ажиллагааны бусад зардал	-1,345	-473	-480	-495	-1,448
Татварын өмнөх ашиг	2,865	1,392	1,463	1,464	4,319
Татварын зардал	-305	-145	-153	-357	-654
Цэвэр ашиг	2,560	1,248	1,310	1,107	3,665

**ХАРЬЦАА ҮЗҮҮЛЭЛТҮҮД:**

	2018	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал	2019
<b>Ашигт ажиллагаа</b>					
Зардлын орлогод эзлэх хувь	35.80%	28.40%	28.40%	29.40%	28.70%
Цэвэр хүүгийн зөрүү	33.60%	9.40%	8.60%	7.90%	21.60%
Өөрийн хөрөнгийн өгөөж	19.20%	9.00%	8.80%	6.90%	23.00%
Активын өгөөж	10.50%	3.70%	2.70%	2.20%	7.20%
<b>Өсөлтийн харьцаанууд</b>					
Активын өсөлт	241.20%	37.40%	43.50%	5.90%	109.00%
Зээлийн багцын өсөлт	347.90%	59.60%	20.20%	19.70%	129.60%
Өөрийн хөрөнгийн өсөлт	121.90%	3.40%	7.60%	7.50%	19.50%
<b>Активын чанар</b>					
Зээлийн активт эзлэх хувь	79.00%	91.70%	76.80%	86.80%	86.80%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	38.50%	9.30%	29.30%	17.90%	17.90%
<b>Өөрийн хөрөнгийн харьцаа</b>					
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ	61.30%	32.30%	32.50%	27.50%	27.50%
Өөрийн хөрөнгийн хүрэлцээ	61.30%	32.30%	32.50%	27.50%	27.50%

**ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ /САЯ ТӨГРӨГ/**


	2018	2019 1-р улирал	2019 2-р улирал	2019 3-р улирал
Нийт зээлийн багц	19,210	30,652	36,850	44,100
Хэвийн зээл	18,518	29,293	34,817	41,364
Багцад эзлэх хувь	96.4%	95.6%	94.5%	93.8%
Хугацаа хэтэрсэн зээл	349	791	1,032	1,347
Багцад эзлэх хувь	1.8%	2.6%	2.8%	3.1%
Чанаргүй зээл	343	568	1,001	1,390
Багцад эзлэх хувь	1.8%	1.9%	2.7%	3.2%
<b>Эрсдлийн сан</b>				
Эрсдлийн сангийн хүрэлцээ	444	710	1,058	1,373
Эрсдлийн сангийн хүрэлцээ	129%	125%	106%	99%

2019 оны 2-р улирлын байдлаар Банк бус санхүүгийн салбарын нийт зээл 1,097 тэрбум төгрөг байсанаас Хэвийн зээл 956 тэрбум (87.1%), Хугацаа хэтэрсэн зээл 43 тэрбум (3.9%), Чанаргүй зээл 97 тэрбум (8.9%) байсан.

## ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

### НЭГ ӨДРИЙН АЖИЛЖААНЫ ДУНДАЖ ДҮН


(2019 ОН 3-Р УЛИРАЛ)



Эх сурвалж: МХБ


### БИРЖИЙН НИЙТ АРИЛЖСАН ХУВЬЦААНД ЭЗЛЭХ ХУВЬ

(2019 ОН 3-Р УЛИРАЛ)



### БИРЖИЙН НИЙТ АРИЛЖААНЫ ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

(2019 ОН 3-Р УЛИРАЛ)



● ЛЭНДМН 
 ● АРД ДААТГАЛ 
 ● АПУ 
 ● ГОВЬ 
 ● ТАВАН ТОЛГОЙ 
 ● МОНГОЛ ШУУДАН 
 ● МАНДАЛ ДААТГАЛ 
 ● БУСАД

Эх сурвалж: МХБ



## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

“ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2019 оны 3 дугаар улиралд ээлжит болон ээлжит бус байдлаар 2 удаа хуралдсан болно.

ТУЗ-ийн хурлаас гарсан онцлох шийдвэрүүдийг дурьдвал:

- Төлөөлөн Удирдах зөвлөлийн даргаар Б.Дэлгэржаргалыг сонгох;
- Компанийн Гүйцэтгэх захирлаар О.Болдбаатарыг томилох;
- ТУЗ-ийн зарим хороодын бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах;
- Компанийн бүтцийг шинэчлэн батлах тухай;
- Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Улаанбаатар банк болон Капитрон банкнаас зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай;
- Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааны чиглэл нэмэх;
- Чанаргүй болон муу активыг Зээлийн эрсдэлийн сангаас хорогдуулах эрх олгох тухай шийдвэрүүдийг тус тус гаргасан болно.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрүүдийг Монголын Хөрөнгийн Биржийн (<http://mse.mn/mn>) цахим хуудаснаас харах боломжтой.

Холбоо барих:

“ЛэндМН ББСБ” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Мөнхцэцэг

Утас: 99018886

И-мэйл: [board@lendmn](mailto:board@lendmn)



LENDMN АППЛИКЕЙШН ДАВХАРДСАН ТООГООР  
**1 САЯ УДАА ТАТАГДЛАА**

